



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 01 дүгээр сарын 27 өдөр

Дугаар 11

Хэрлэн сум

Х ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 11 дүгээр хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 95,8 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Улаанбаатар Төмөрзамын Баянтүмэн тасгаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн албан бичгийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2.Давтан шинжилгээний зохион байгуулалтын талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

3.Хэрлэн номин бизнес төв, 2 дугаар багт байрлах спорт заал, Повер фитнес клубт хяналт шалгалт хийсэн дүгнэлт, мэдээлэл танилцуулах,

Мэргэжлийн хяналтын газар,

Эрүүл мэндийн газар

4.Тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн үнэ тарифын талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

5.Улаанбаатар хот руу зорчих зайлшгүй шалтгаантай иргэдийг хүсэлтийг хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа,

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн, хурандаа Б.Бямбаа,

/  / М.Бадамсүрэн
/  / Э.Ганжигүүр

Гаалийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Б.Гэрэлт-од нарт:

1.1.ОХУ-аас хилийн Эрэнцав боомтоор зөвшөөрөлгүй нэвтэрсэн овьёос тээвэрлэлтэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Тагнуулын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Гаалийн газрын мэргэжлийн байгууллагын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулж Эрэнцав хилийн боомтоор орж ирсэн бараа материалд хяналт, шалгалтыг зохион байгуулахыг,

1.1.Улсын Онцгой комисс, Улаанбаатар төмөр замын Баянтүмэн тасгаас аймгийн Онцгой комисст “ОХУ-аас Дорнод аймагт 22 вагон төмөр замын дэр модыг хилийн Эрэнцав боомтоор Чойбалсан хот руу тээвэрлэх зөвшөөрөл хүсэх тухай” албан бичгийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 239 дүгээр тогтоолын 3 дахь заалт, Монгол Улсын хувь нийлүүлсэн нийгэмлэгийн зайлшгүй албан хэрэгцээнд хэрэглэх шаардлагатайг үндэслэн улсын хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Чойбалсан хотын захирагч бөгөөд Хэрлэн сумын Засаг дарга,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

1.3.Хилийн Эрэнцав боомтоор нэвтэрч төмөр замаар тээвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг ачих, буулгах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.4.Хилийн Эрэнцав боомтоор тээвэрлэж ирсэн төмөр замын дэр модыг буулгах үйл ажиллагаанд оролцсон ажилчдыг халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, бэлтгэсэн тусгаарлах байранд 7 хоног тусгаарлаж зохион байгуулах тухай үүргийг Эрүүл мэндийн байгууллагаас санал авч Улаанбаатар төмөр замын Баянтүмэн тасагт албан бичгийг хүргүүлэхийг,

Улаанбаатар төмөр замын Баянтүмэн тасгийн
дарга П.Түвшинжаргал-д:

1.5.Хяналт, шалгалтын ажлын хэсгийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж хамтран ажиллахыг,

Гаалийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Б.Гэрэлт-од,
Улаанбаатар төмөр замын Баянтүмэн тасгийн
дарга П.Түвшинжаргал,
Хилийн дугаар ангийн захирагч,
хурандаа О.Баттулга нарт:

1. Он / М.Бадамсүрэн
1. 2. Ганжигүүр

1.6.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 195, 239 дүгээр тогтоолын дагуу хилийн боомтоор төмөр замын тээвэрлэлт хийх тухай ОХУ-ын төмөр замын байгууллагад албан бичгийг хүргүүлж санал солилцохыг,

Хоёр.Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

2.1.Улаанбаатар хотоос татан авалтаар ирсэн иргэдээс давтан шинжилгээ авах ажлын хэсгүүд Биеийн тамир спортын газар, Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газрын тээврийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглах, Автотээврийн төвөөс 1 тээврийн хэрэгслийг судалж шийдвэрлэхийг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

2.2.Давтан шинжилгээ авах ажлын хэсгийн зорчих маршрутыг боловсруулж батлуулахыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

2.3.Улаанбаатар хотоос татан авалтаар ирсэн иргэдээс давтан шинжилгээ авах үйл явцад хяналт тавьж ажиллахыг,

Гурав.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

3.1.Мэргэжлийн байгууллагын бүрэлдэхүүнтэй хяналт, шалгалтын багийн дүгнэлтийг үндэслэн 1 танхимд хүний тоо 10-аас ихгүй байх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж Повер фитнес клубын үйл ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрөв,



Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

3.2.Хэрлэн номин бизнес төвийн спорт зааланд хяналт, шалгалт хийсэн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэхийг,

Чойбалсан хотын захирагч бөгөөд Хэрлэн сумын Засаг дарга, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-т:

3.3.Чойбалсан хотын айл өрхүүдэд тээврийн хэрэгслээр ус түгээх хуваарийг гаргаж батлуулахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

 / М.Бадамсүрэн
 / Э.Анжигүүр

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт:

3.4.Чойбалсан хотын айл өрхүүдэд тээврийн хэрэгслээр ус түгээх ажилд зөвлөмж өгч, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг,

Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

4.1.Тээврийн хэрэгслийн загвар, овор хэмжээгээр нь ангилж халдваргүйтгэл хийх үнэ тогтоох, ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагуудтай уулзалт зохион байгуулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд санал танилцуулахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

4.2.Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн санд байгаа БНХАУ-аас хүмүүнлэгийн тусламжаар хандивласан ариутгалын бодисыг шинжилгээнд хамруулж хэрэглэх боломжтой эсэх талаар дүгнэлтийг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Төв.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

5.1.Тусгай зөвшөөрөлтэй "Хан цайз" ХХК-ийн 2 тээврийн хэрэгслээр Улаанбаатар хот руу явах хүндэтгэн үзэх шалтгаантай хүсэлт өгсөн иргэдийг Улаанбаатар хот руу зорчуулах, буцахдаа зөвхөн карго ачааг Эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу туршилтын хугацаанд хяналттайгаар тээвэрлэхийг зөвшөөрөв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН АХМАД Э.ГАНЖИГУҮР

